



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2014 оны 2 дугаар сарын байдлаар)



1. Хүн ам

ЭМГ-аас эрхлэн гаргадаг мэдээгээр 2014 оны эхний 2 сард 226 хүүхэд шинээр мэндэлж, 62 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 164 болж 2013 оны мөн үеийнхээс 19.2 хувиар буюу 39-өөр буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 3.6, нас баралт 1.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.7 пунктээр буурч, нас баралт адил байна.



2. Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэд 2014 оны эхний 2-р сарын байдлаар 1388 байгаа нь өмнөх оны мөн үеэс 47,3 хувиар өсч, 2013 оны жилийн эцсийн дүнгээс 8,8 хувиар буурсан байна.

Бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн 55,0 хувийг эмэгтэйчүүд, 34.0 хувийг бүрэн дунд, 23.7 хувийг дипломын болон бакалаврын дээд, 21.7 хувийг суурь, 10.0 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.3 хувийг техник болон мэргэжлийн, 3.1 хувийг бага, 0.7 хувийг боловсролгүй, 0.5 хувийг магистр/ докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 125 ажлын байрны захиалга иржээ.



3. Нийгмийн даатгал, халамж

2014 оны эхний 2 сард нийгмийн даатгалын санд 3 269,0 сая төгрөгийн орлого төвлөрч, 3 826,2 сая төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгожээ.

Оны эхний 2 сард нийгмийн халамжийн сангаас 1269 иргэнд 282,0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр олгожээ.



4. Эрүүл мэнд

Он гарсаар 65.8 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар, 2.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь 13.6 хувиар нэмэгдэв. Урьдчилан сэргийлэх тарилгад 0.9 мянган хүн хамрагдсан нь 10 хувиар буурлаа.

Ослын улмаас 276 хүн бэртэж, 16 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ослын улмаас бэртсэн хүний тоо 34.6 хувиар буурч, нас барсан хүний тоо 45.5 хувиар нэмэгджээ.

Халдварт өвчний 187 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 109-өөр буюу 34.4 хувиар буурсан байна.



5. Байгаль орчин

Цаг уур: 2014 оны 2 дугаар сард агаарын температур нийт нутгаар -11.7 хэм байсан нь олон жилийн дунджаас 0,3 хэмээр дулаан байлаа.

Хөрсөн дээр шөнөдөө -27 хэмээс 32 хэм хүртэл хүйтэн байсан бол өдөртөө хамгийн дулаан нь 10-24 хэм дулаан, дунджаар -12 хэм хүйтэн байв. Хур тунадастай хоногийн тоо 1-3 өдөр байв.



6. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 2 сард 87 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 4 хүн нас барж, 31 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 10-аар буурсан байна.



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 54,3 сая төгрөгийн хохирол учирсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69.8 сая төгрөгөөр буюу 56.2 хувиар буурсан байна. Учирсан хохирлын 55.4 хувь нь эргэн төлөгджээ.

Нийт гэмт хэргийн 48.3 хувийг согтуугаар, 31.0 хувийг гэр сууцандаа, 9.2 хувийг гудамж олон нийтийн газарт, 14.9 хувийг бүлэглэн, 19.5 хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 59.8 хувийг шөнө, оройн цагаар үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 452 хүн эрүүлжүүлэгдэж, 31 хүн баривчлагджээ.



7. Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 65,8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 18,2 хувь, цэвэр зарлага 67,3 тэрбум төгрөг болж 30,6 хувиар буурчээ.

Иргэдийн мөнгөн хадгаламж 25,6 тэрбум төгрөг болж, хадгаламж эзэмшигчийн тоо 16,6 хувь, хадгаламжийн үлдэгдэл 8.3 хувиар тус тус өсчээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн өрийн үлдэгдэл 48,8 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 15,5 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 3,7 хувиар тус тус өсөв.



8. Төрийн санхүү

2014 оны эхний 1 сард орон нутгийн төсөвт 1120,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Орон нутгийн төсвийн орлогын 84,4 хувийг татварын, 5.7 хувийг татварын бус орлого, 9,8 хувийг тусламжийн орлого бүрдүүлсэн байна.



9. Үнэ

Ерөнхий индекс өмнөх сарынхаас 1.4 хувиар өсөхөд зочид буудал, зоогийн газар, дотуур байрны бүлэг 16,1 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 6,9 хувь, хүнсний бараа, ундаа, усны бүлэг 2,1 хувь, хувцас, бөс бараа, гуталын бүлэг 0,8 хувь, гэр ахуйн тавилга, барааны бүлэг 0,4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеийнхээс (2014 оны 2-р сар) 23,2 хувь өсөхөд тээвэр 43.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлэг 50,6 хувь, боловсролын бүлэг 17,5 хувь, гэр ахуйн тавилга, барааны бүлэг 17,5, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 15,4 хувь, согтууруулах ундаа тамхи бүлэг 7,7 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээ 27,9 хувь, хүнсний бараа, ундаа, усны бүлэг 12,3 хувь, бусад, бараа үйлчилгээний бүлэг 24,0 хувь нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.



10. Хөдөө аж ахуй

Оны эхний 2 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 0.7 хувь буюу 4238 толгой мал төллөж, төл бойжилт 100.0 хувьтай байна.

2014 оны 2 сарын байдлаар 728 толгой том мал хорогдсон нь оны эхний малын 0.05 хувьтай тэнцэж байна. 2013 оны мөн үед хорогдсон малын тооноос 61.0 хувиар өсчээ. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь 89.0 буюу 648 толгой мал хорогдож өмнөх оны мөн үеэс 35,0 пунктээр нэмэгджээ. Хорогдлын 88.2 хувийг үхэр эзэлж байна.



11. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт эхний 2 сард оны үнээр 1486.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1284.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өмнөх оноос 27.1 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 16.1 хувиар нэмэгдсэн байна.